



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/85/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Дорнод аймаг

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудит газрын дарга бөгөөд  
тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: С.Энхбаатар

Утас: 70584207 Цахим хаяг: Enkhbaatars@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Аудитын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НББ	Нягтлан бодох бүртэл



Агуулга

<b>Аудитын гэрчилгээ</b> .....	3
Аудитын тайлан .....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.11. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.12. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.13. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.14. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.15. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.16. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
Менежментийн захидал .....	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	12
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	16



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.13 № 53

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.АЛИММАА  
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

2020.02.13 №53

D: Mv computer – TOOT A4

110519535



**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.1. Оршил

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Алимаа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-наас 2020 оны 02 дугаар сарын 09-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 11-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор С.Энхбаатар хариуцаж хэрэгжүүлэв.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 15-ний өдрийн 28 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас

санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Хүнс, хөдөө аж ахуйн газрын эрхэм зорилго нь өөрийн аймаг болон бүс нутагт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжлийг түргэтгэх, зах зээлийн нөхцөлд тэргүүлэх бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, хүн амыг экологийн цэвэр, эрүүл бүтээгдэхүүнээр хангах эх суурийг тавих явдал юм.

Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Салбарын бодлого төлөвлөлт;
- Хүнсний үйлдвэрлэл;
- Мал аж ахуйн үйлдвэрлэл;
- Газар тариалангийн үйлдвэрлэл;
- Жижиг дунд үйлдвэрлэл гэсэн үйл ажиллагааны чиглэл бүхий төрийн байгууллага мөн.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд АСОЛУОС программ хангамж ашигладаг байна.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Хүнс, хөдөө аж ахуйн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,909,202.8 мянган төгрөгөөс тооцон 38,184.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 12,720.4 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл буурсантай холбоотой байна.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,243,899.3 мянган төгрөгөөр буюу 76,9 хувиар буурсан байна. Энэ нь тус байгууллагаас Мал эмнэлгийн газарт 1,496,507.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 344,709.4 мянган төгрөгийн бараа материалыг балансаас балансад шилжүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт Б	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	1.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	464,127.5	136,586.3	327,541.2
Үндсэн хөрөнгө	1,152,798.2	236,441.1	916,357.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,616,926.7</b>	<b>373,027.4</b>	1,243,899.3
Өр төлбөр	0,0	291.6	291.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,616,926.7	372,735.8	1,244,190.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,616,926.7</b>	<b>373,027.4</b>	1,243,899.3

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь тус газраас шинээр байгуулагдсан Мал эмнэлгийн газарт 344,709.4 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө өмнөх оноос буурсан нь мөн Мал эмнэлгийн газарт хөрөнгө шилжүүлсэнтэй холбоотой байна.

Өр төлбөрийн үлдэгдэлтэй гарсан нь цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгасан татварын тооцооллын алдаанаас шалтгаалж өр үүсгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 372,735.8 мянган төгрөг болж 1,244,190.9 мянган төгрөгөөр буурсан нь үйл ажиллагааны үр дүн буурснаас шалтгаалжээ. Энэ нь хөрөнгө шилжүүлсэнтэй холбоотой байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаанд зориулан 253,990.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 253,990.2 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 249,463.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт төсөв:** Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 62,784.1 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 234,021.4 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 273.9 мянган төгрөг, нийт 297,079.4 мянган төгрөгийн нэмэлт төсвийг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 227,606.9 мянган төгрөг, бараа, үйлчилгээний бусад зардалд 69,472.5 мянган төгрөг, нийт 297,079.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 15 эрсдэл тодорхойлж нийт 15 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 38,008.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 29,900.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 5,669.9 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах 1 зөвлөмж, 2437.7 мянган төгрөгийн алдаанд залруулга хийлгэлээ.

Аудитаар 38,008.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 29,900.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Багаж, техник хэрэгслийн зардлаас 9908.9 мянган төгрөг, мэдээлэл технологийн зардлаас 1500.0 мянган төгрөг, нийт 11408.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө /биет болон биет бус/-ийг зохих шийдвэргүйгээр урсгал зардлаас бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан *“Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1.2-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ.”*, 2.1-д *“Төрийн өмчит хуулийн этгээд нь энэ журмын 1.2-т заасан асуудлыг шийдвэрлүүлэхдээ дор дурдсан бичиг баримтаас тухайн харилцаанд хамааралтай баримт, материалыг бүрдүүлнэ”* гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
2. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас томилолтын зардалд 2369.2 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д



*“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”* гэсэн заалтад нийцэхгүй, санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3. Бараа материалын худалдан авалтын 11424.4 мянган төгрөгийн анхан шатны баримтад е-баримтыг хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 3.1.3-д *“анхан шатны баримт гэж ....., төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”*, 13.4-д *“Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”*, 13.5-д *“... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”*, Төсвийн тухай хуулийн 41.2.3-д *“төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”*, 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан *“Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын 6.5, Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах”* гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
4. Малын данс бүртгэлийн үнэ зах зээлийн үнэлгээнээс хэт доогуур байгаа нь НББОУС 41, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д *“үнэн зөв байх”* гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар илэрсэн 5669,9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц асуудал байхгүй.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 685.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосноос 685.2 мянган төгрөгийг бүрэн барагдуулсан, 2,280.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж, хэрэгжилт 100,0 хувьтай байна.

## 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### “Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дугаар зүйл, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1. МУЕА-аас өгсөн чиглэлийн дагуу суудлын автомашины ашиглалтын талаар*

1.1. Илрүүлэлт: Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нь Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолд заасны дагуу албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтад хамаарахгүй байхад тодорхой ажлын гүйцэтгэлгүйгээр 5,669.9 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан байна.

1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах

1.3. Өгсөн зөвлөмж: Засгийн газраас гаргасан тушаал шийдвэрийг мөрдөж ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийг мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>464,128,480.51</u></b>	<b><u>136,586,328.52</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	927.45	00.00
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	927.45	00.00
31110	Төгрөг	927.45	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	464,127,553.06	136,586,328.52
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	371,637,856.66	46,890,221.90
35110	Тусгай зориулалттай материал	210,144,046.30	45,525,844.01
35130	Эм боох материал	161,493,810.36	1,364,377.89
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	29,115,696.40	25,464,106.62
35410	Бичиг хэргийн материал	1,942,900.00	2,004,800.00
35420	Аж ахуйн материал	23,087,074.40	12,889,806.62
35430	Сэлбэг хэрэгсэл	3,739,500.00	10,559,500.00
35470	Бусад хангамжийн материал	346,222.00	10,000.00
35600	Мал амьтад	63,374,000.00	64,232,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,152,798,222.25</u></b>	<b><u>236,441,068.47</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,152,798,222.25	236,441,068.47
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	948,598,222.25	161,581,068.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	650,551,604.00	122,607,151.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-3,735,759.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	356,780,397.87	126,768,274.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	-257,182,858.77	-106,036,958.72
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	623,746,921.23	35,563,523.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	-437,940,603.07	-21,011,187.30
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,056,595.13	16,102,546.13
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,413,834.14	-8,676,521.02
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,505,000.00	00.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,505,000.00	00.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	204,200,000.00	74,860,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	204,790,000.00	76,290,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-590,000.00	-1,430,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,616,926,702.76</u></b>	<b><u>373,027,396.99</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>291,611.75</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	291,611.75
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	291,611.75
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	291,611.75
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,616,926,702.76</u></b>	<b><u>372,735,785.24</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,616,926,702.76	372,735,785.24
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	809,992,767.15	809,992,767.15
51101	Өмч: - төрийн	809,992,767.15	809,992,767.15
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	205,149,139.32	-445,282,827.22
51210	Өмнөх үеийн үр дүн	205,149,139.32	798,908,090.30
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-1,244,190,917.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	601,784,796.29	8,025,845.31
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,616,926,702.76</u></b>	<b><u>373,027,396.99</u></b>

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,964,763,076.47</b>	<b>567,832,457.13</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>770,477,796.47</b>	<b>15,262,919.13</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>770,477,796.47</b>	<b>15,262,919.13</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	770,477,796.47	2,963,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,651,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	768,826,796.47	2,963,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн бараа материал		12,299,919.13
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,194,285,280.00</b>	<b>552,569,538.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>286,189,600.00</b>	<b>255,490,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	286,189,600.00	255,490,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>908,095,680.00</b>	<b>297,079,438.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	395,387,110.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	508,595,470.00	296,805,569.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,113,100.00	273,869.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,909,202,824.14</b>	<b>636,018,717.46</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,909,202,824.14</b>	<b>636,018,717.46</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,889,329,824.14</b>	<b>628,491,287.46</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>205,244,072.55</b>	<b>154,584,139.20</b>
210101	Үндсэн цалин	155,801,000.00	122,796,439.20
210102	Нэмэгдэл	29,285,172.55	25,278,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,172,800.00	6,509,400.00
210104	Урамшуулал	00.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,985,100.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>24,629,500.00</b>	<b>19,286,400.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	16,419,600.00	13,114,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,052,600.00	1,542,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,642,000.00	1,234,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	410,500.00	308,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,104,800.00	3,085,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,235,000.00</b>	<b>5,190,836.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,574,700.00	1,574,700.00
210302	Түлш, халаалт	8,879,500.00	2,435,336.00
210303	Цэвэр, бохир ус	780,800.00	1,180,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>39,432,921.79</b>	<b>9,914,068.00</b>
210401	Бичиг хэрэг	3,491,110.00	1,558,850.00
210402	Тээвэр, шатахуун	19,367,100.00	7,211,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,142,900.00	816,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,805,784.82	327,168.00
210408	Бараа материал акталсны зардал	11,626,026.97	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>604,942,028.98</b>	<b>00.00</b>

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	604,942,028.98	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,568,736.58</b>	<b>3,181,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,101,236.58	2,287,500.00
210604	Урсгал засвар	467,500.00	894,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,128,200.00</b>	<b>6,069,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,128,200.00	6,069,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>819,038,630.00</b>	<b>253,563,638.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	817,206,730.00	251,910,004.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	623,700.00	535,650.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	387,200.00	195,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	341,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00
210807	Газрын төлбөр	480,000.00	485,184.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>173,110,734.24</b>	<b>176,700,906.26</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	84,570,690.00	80,230,093.88
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	88,540,044.24	96,470,812.38
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>19,873,000.00</b>	<b>7,527,430.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>19,721,976.00</b>	<b>1,500,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,221,976.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,500,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>151,024.00</b>	<b>6,027,430.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	151,024.00	6,027,430.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>55,560,252.33</b>	<b>-68,186,260.33</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>1,176,004,657.19</b>
225010	Үнэ төлбөргүй гарсан үндсэн хөрөнгө	00.00	831,295,241.40
225011	Үнэ төлбөргүй гарсан бараа материал	00.00	344,709,415.79
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-1,176,004,657.19</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>55,560,252.33</b>	<b>-1,244,190,917.52</b>

#### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,195,936,280.00</b>	<b>552,569,538.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,651,000.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,651,000.00</b>	<b>00.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	1,651,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,651,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,194,285,280.00</b>	<b>552,569,538.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>286,189,600.00</b>	<b>255,490,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	286,189,600.00	255,490,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>908,095,680.00</b>	<b>297,079,438.00</b>

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	395,387,110.00	62,784,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	508,595,470.00	234,021,469.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,113,100.00	273,869.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,195,935,352.55</b>	<b>552,570,465.45</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,195,935,352.55</b>	<b>552,570,465.45</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,176,062,352.55</b>	<b>545,043,035.45</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	205,244,072.55	154,292,527.45
210101	Үндсэн цалин	155,801,000.00	122,504,827.45
210102	Нэмэгдэл	29,285,172.55	25,278,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,172,800.00	6,509,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,985,100.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	24,629,500.00	19,286,400.00
210201	Тэтгэврийн даатгал	16,419,600.00	13,114,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,052,600.00	1,542,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,642,000.00	1,234,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	410,500.00	308,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,104,800.00	3,085,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,235,000.00	5,190,836.00
210301	Гэрэл, цахилгаан	3,574,700.00	1,574,700.00
210302	Түлш, халаалт	8,879,500.00	2,435,336.00
210303	Цэвэр, бохир ус	780,800.00	1,180,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,773,900.00	9,638,400.00
210401	Бичиг хэрэг	1,441,100.00	1,610,350.00
210402	Тээвэр, шатахуун	7,189,900.00	7,211,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,142,900.00	816,750.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	2,860,400.00	2,235,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,424,800.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,435,600.00	2,235,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,531,700.00	21,210,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,256,400.00	11,986,000.00
210604	Урсгал засвар	1,275,300.00	9,224,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,391,600.00	6,069,800.00
210702	Дотоод албан томилолт	4,391,600.00	6,069,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	837,065,080.00	255,337,507.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	835,233,180.00	252,183,873.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	623,700.00	535,650.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	387,200.00	195,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	341,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,500,000.00
210807	Газрын төлбөр	480,000.00	485,184.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	74,331,100.00	71,781,965.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	74,331,100.00	71,781,965.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>19,873,000.00</b>	<b>7,527,430.00</b>

2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	19,721,976.00	1,500,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,221,976.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,500,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	151,024.00	6,027,430.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	151,024.00	6,027,430.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>927.45</b>	<b>-927.45</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	927.45	-927.45
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	927.45
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	927.45	00.00

#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/ төгрөгөөр / Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	609,992,767.15	982,856.99	336,383,532.74	00.00	947,359,156.88
C03	Дахин илэрхийлсэн	609,992,767.15	982,856.99	336,383,532.74	00.00	947,359,156.88
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-186,794,645.75	00.00	-186,794,645.75
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	809,992,767.15	601,784,796.29	205,149,139.32	00.00	1,616,926,702.76
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	809,992,767.15	601,784,796.29	205,149,139.32	00.00	1,616,926,702.76
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	593,758,950.98	00.00	593,758,950.98
D03	Дахин илэрхийлсэн	809,992,767.15	601,784,796.29	798,908,090.30	00.00	2,210,685,653.74
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,	00.00	-593,758,950.98	00.00	00.00	-593,758,950.98
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,244,190,917.52	00.00	-1,244,190,917.52
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	809,992,767.15	8,025,845.31	-445,282,827.22	00.00	372,735,785.24

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан / төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	253,990,150.00	249,463,597.45
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	253,990,150.00	249,463,597.45
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	252,490,150.00	247,963,597.45
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	154,291,600.00	154,292,527.45
210101	Үндсэн цалин	122,503,900.00	122,504,827.45
210102	Нэмэгдэл	25,278,300.00	25,278,300.00

210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,509,400.00	6,509,400.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	19,286,400.00	19,286,400.00
210201	Тэтгэврийн даатгал	13,114,800.00	13,114,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,542,900.00	1,542,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,234,300.00	1,234,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	308,600.00	308,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,085,800.00	3,085,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	8,574,800.00	5,190,836.00
210301	Гэрэл, цахилгаан	1,574,700.00	1,574,700.00
210302	Түлш, халаалт	5,819,300.00	2,435,336.00
210303	Цэвэр, бохир ус	1,180,800.00	1,180,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,638,400.00	9,638,400.00
210401	Бичиг хэрэг	1,541,100.00	1,610,350.00
210402	Тээвэр, шатахуун	7,280,600.00	7,211,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	816,700.00	816,750.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	2,235,600.00	2,235,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,235,600.00	2,235,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	23,853,500.00	21,210,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,678,200.00	11,986,000.00
210604	Урсгал засвар	12,175,300.00	9,224,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,069,800.00	6,069,800.00
210702	Дотоод албан томилолт	6,069,800.00	6,069,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	26,230,650.00	27,730,634.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,577,000.00	24,577,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	535,650.00	535,650.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	195,800.00	195,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,500,000.00
210807	Газрын төлбөр	485,200.00	485,184.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2309400.00	2309400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,309,400.00	2,309,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1500000.00	1500000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,500,000.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	255,578,200.00	249,462,670.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	255,490,100.00	249,462,670.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	255,490,100.00	249,462,670.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	28.00	20.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	15.00
620003	Үйлчлэх ажилтан	11.00	04.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00